



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 05 өдөр

Дугаар 8/32

Чингис хот

Шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, Засгийн газрын 1997 оны “Аймаг нийслэлийн Засаг даргын олгох шагналын тухай” 54 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол улсад Прокурорын байгууллага үүсч хөгжсөний 90 жилийн ойг тохиолдуулан салбартаа олон жил үр бүтээлтэй ажилласан нэр бүхий иргэдийг Засаг даргын жуух бичиг, мөнгөн шагналаар шагнасугай.

2. Шагнагдах иргэдийн нэрсийг нэгдүгээр, зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах 84.000 /наян дөрвөн мянга/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн шагнал урамшуулал, буцалтгүй тусламжийн зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

08 Аймгийн Засаг даргын 2020 оны
дугаар сарын 05 өдрийн 6/БЭ
дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

Жуух бичгээр шагнагдах иргэдийн нэрс

№	Нэрс	Албан тушаал
1	Н.Амгалан	Бор-Өндөр сум дахь сум дундын Прокурорын газрын туслах ажилтан
2	С.БатОрших	Бор-Өндөр сум дахь сум дундын Прокурорын газрын туслах ажилтан

Аймгийн Засаг даргын 2020 оны
08 дугаар сарын 05 өдрийн 6/32
дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

Зардлын тооцоо

№	Нэрс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Жуух хэвлүүлэх	2	12.000	24.000
2	Мөнгөн шагнал	2	30.000	60.000
	Нийт			84.000